

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ МОНГОЛ СЭТГҮҮЛ
“АРА” стилээр эш татах, хүснэгт, зураг дугаарлах, ном зүй хийх зарим жишээ

1. Эшлэл

Дээд боловсролын эдийн засгийн үр өгөөжийг сэтгэл зүйн болон нийгмийн гэж хуваан үзсэн байдаг (Оюунчимэг & Энхцэцэг, 2019).

[шууд бус эшлэл буюу эшилж буй зохиогчийн санааг утгыг нь алдагдуулахгүйгээр өөрийн үгээр тайлбарлан хэрэглэх]

Оюунчимэг, Энхцэцэг нар (2019)-ын үзсэнээр дээд боловсролын эдийн засгийн үр өгөөжийг сэтгэл зүйн болон нийгмийн гэж хуваадаг.

[шууд бус эшлэл буюу эшилж буй зохиогчийн санааг утгыг нь алдагдуулахгүйгээр өөрийн үгээр тайлбарлан хэрэглэх; эш татаж буй зохиогчдын нэрийг өгүүлбэрт хэрэглэх байдал]

“Дээд боловсролын эдийн засгийн үр өгөөжийг сэтгэл зүйн болон нийгмийн гэж хуваан үзсэн байдаг” (Оюунчимэг & Энхцэцэг, 2019, х. 35).

[шууд эшлэл буюу эшилж буй зохиогчийн санааг тэр чигээр нь хэрэглэх]

Оюунчимэг, Энхцэцэг нар (2019)-ын үзсэнээр дээд боловсролын эдийн засгийн үр өгөөжийг “сэтгэл зүйн болон нийгмийн” (х. 35) гэж хуваадаг.

[шууд эшлэл буюу эшилж буй зохиогчийн санааг тэр чигээр нь хэрэглэх; эш татаж буй зохиогчдын нэрийг өгүүлбэрт хэрэглэх байдал; зөвхөн шууд эшилсэн хэсгийг хашилтанд хийсэн байдал]

Эш татаж буй материал нь гурван зохиогчтой бол (Дорж, Бат & Болд, 2022), дөрөв ба түүнээс олон зохиогчтой бол (Дорж & бусад, 2022) гэж эшилнэ.

Хэд хэдэн эш зэрэг авах бол тухайн эш татаж буй материалын эхний зохиогчийн нэрийн үсгийн дарааллаар байрлуулна. Жишээ нь “(Бат & Дорж, 2022; Дорж, 2022; Гэрэл, 2022)” гэх мэт.

Тав болон түүнээс дээш мөр бүхий хэсгийг шууд эш татах бол шинэ мөрнөөс эхлэн, хашилтан дотор бичнэ. Жишээ нь:

“Тав болон түүнээс дээш мөр бүхий хэсгийг шууд эш татах бол шинэ мөрнөөс эхлэн, хашилтан дотор бичнэ. Тав болон түүнээс дээш мөр бүхий хэсгийг шууд эш татах бол шинэ мөрнөөс эхлэн, хашилтан дотор бичнэ. Тав болон түүнээс дээш мөр бүхий хэсгийг шууд эш татах бол шинэ мөрнөөс эхлэн, хашилтан дотор бичнэ. Тав болон түүнээс дээш мөр бүхий хэсгийг шууд эш татах бол шинэ мөрнөөс эхлэн, хашилтан дотор бичнэ (Дорж & бусад, 2022, х. 6).”

Насанд хүрэгчидтэй ажилладаг багш нар өөрсдийгөө хэрхэн тодорхойлох нь мэргэжилтний хувьд тэд хэн байх вэ, хэрхэн ажиллах вэ, нийгэмд ямар байр суурь эзлэх вэ гэдэг асуултын гаргалгааг илэрхийлдэг мэргэжлийн толь учраас үүнийг судлах нь зайлшгүй чухал (Beauchamp & Thomas, 2009; Yeung, Craven & Kaur, 2014).

[Хувилбар 1: шууд бус эшлэл; гадаад зохиогчийн нэрийг галиглан орчуулалгүйгээр хэрэглэсэн байдал]

Насанд хүрэгчидтэй ажилладаг багш нар өөрсдийгөө хэрхэн тодорхойлох нь мэргэжилтний хувьд тэд хэн байх вэ, хэрхэн ажиллах вэ, нийгэмд ямар байр суурь эзлэх вэ гэдэг асуултын гаргалгааг илэрхийлдэг мэргэжлийн толь учраас үүнийг судлах нь зайлшгүй чухал (Beauchamp & Thomas, 2009; Юнг, Кравен & Каур, 2014).

[Хувилбар 2: шууд бус эшлэл; гадаад зохиогчийн нэрийг галиглан орчуулж хэрэглэсэн байдал]

Беаучамп, Томас нар (2009), Юнг, Кравен, Каур нар (2014)-ын үзсэнээр насанд хүрэгчидтэй ажилладаг багш нар өөрсдийгөө хэрхэн тодорхойлох нь мэргэжилтний хувьд тэд хэн байх вэ, хэрхэн ажиллах вэ, нийгэмд ямар байр суурь эзлэх вэ гэдэг асуултын гаргалгааг илэрхийлдэг мэргэжлийн толь учраас үүнийг судлах нь зайлшгүй чухал.

[шууд бус эшлэл; гадаад зохиогчийн нэрийг галиглан орчуулж, өгүүлбэрт хэрэглэсэн байдал]

2. Хүснэгт, зураг, томьёо

Нэн ялангуяа төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежийн тоо 2010 оноос хойш буурч байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Их, дээд сургууль, коллежийн тоо (өмчийн хэлбэрээр)

Он	Улсын дүн	Төрийн өмчийн		Төрийн бус өмчийн		Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын сургууль	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
2010	113	16	14	92	81	5	5
2015	100	17	17	78	78	5	5
2017	96	18	19	75	78	3	3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо (2018)

Багшийн эзэмшсэн чадамж болон багш өөрийн ажлын гүйцэтгэлийн үр дүнгээ үнэлсэн байдлын хооронд харилцан хамаарал ажиглагдаж байна. Тодруулбал, ажлын гүйцэтгэлээ сайн хэмээн үнэлсэн багш нар өөрсдийн чадамжаа хангалттай гэж үнэлсэн бол ажлын гүйцэтгэл тааруу хэмээн үнэлсэн багш нар чадамжаа сул гэжээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Багшийн эзэмшсэн чадамж ба ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Эзэмшсэн чадамж	Бүлгүүд	n	M	SD	t-test	
					t-stat	p-value
Суралцах хэрэгцээг үнэлэх чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	3.86	0.64	6.46	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	2.81	0.75		
Хөтөлбөр боловсруулах, төлөвлөх чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.11	0.60	4.63	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.43	0.60		
Агуулгын (мэргэшсэн чиглэл) чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	3.82	0.79	2.82	0.006***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.24	1.04		
Заах арга зүйн чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.05	0.66	4.90	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.19	0.93		
Явцын болон төгсгөлийн үнэлгээ хийх чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	3.85	0.74	3.41	0.001***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.24	0.70		
Суралцагчдыг дэмжих чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.11	0.68	5.34	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.24	0.62		
Байгууллага, зохион байгуулалтын чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.12	0.65	4.74	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.33	0.80		
Мэргэжлээ дээшлүүлэх чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.08	0.62	4.13	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.43	0.75		
Харилцааны чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.37	0.58	3.64	0.000***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.86	0.57		
Хувийн чадамж	Сайн гүйцэтгэлтэй	84	4.23	0.63	3.33	0.001***
	Тааруу гүйцэтгэлтэй	21	3.71	0.64		

Тэмдэглэл. *** p < .001

Монголын боловсролын системийн онолын загвар (Зураг 1) ёсоор боловсролын чанарыг компонент тус бүрээр тодорхойлох боломжтой хэмээн үздэг (Итгэл, 2018).



Зураг 1. Монголын боловсролын системийн онолын загвар (Итгэл, 2018)

Томьёог “Microsoft Equation Editor” ашиглан оруулна.

$$E_v - E = \frac{h}{2.m} (k_x^2 + k_y^2)$$

3. Ном зүй

Өгүүлэл

Итгэл, М. (2108). Монголын боловсролын чанарын асуудалд. *Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг*, 23. 19–27

Meijer, P. C., Korthagen, F. A. J., & Vasalos, A. (2009). Supporting presence in teacher education: The connection between the personal and professional aspects of teaching. *Teaching and Teacher Education*, 25, 297–308. DOI: 10.1016/j.tate.2008.09.013

Ном

Бэгз, Н. (2008). *Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд*. Соёмбо принтинг.

Боловсролын хүрээлэн. (2018). *Боловсролын хөгжил: Судалгаа, арга зүй*. Гоо дизайн.

Schön, D. A. (1983). *The reflective practitioner: How professionals think in action*. Taylor & Francis.

Steiner-Khamsi, G., & Stolpe, I. (2006). *Educational import: Local encounters with global forces in Mongolia*. Palgrave Macmillan.

Номын бүлэг

Schutz, P. A., Francis, D. C., & Hong, J. (2018). Research on teacher identity: Introduction to mapping challenges and innovation. In P. A. Schutz, D. C. Francis, & J. Hong (Eds.), *Research on teacher identity: Mapping challenges and innovations* (pp. 3–9). Gewerbestrasse: Springer.

Тайлан

Үндэсний статистикийн хороо [ҮСХ]. (2020). *Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллого: Үндсэн үр дүн*. Улаанбаатар, Монгол Улс. Татаж авсан холбоос <http://www.1212.mn>
UNESCO Institute for Lifelong Learning. (2019). *Fourth global report on adult learning and education: Leave no one behind: Participation, equity and inclusion*. Hamburg, Germany: UIL. Retrieved from <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000372274?posInSet=50&queryId=dd248156-5fba-4e3e-8eec-c8365c6356dc>

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл

Оюунчимэг, Д., & Энхцэцэг, Д. (2019, 1-р сарын 17). *Монголын дээд боловсролын эдийн засгийн болон эдийн засгийн бус өгөөж* [Аман илтгэл]. Боловсролын эдийн засгийн тулгамдсан асуудал, шийдэл, арга зам, Улаанбаатар, Монгол Улс.

Milana, M., & Skrypnyk, O. (2009, June 29-30). *Professionals vs. role professionals: Conceptualizing professionalism among teachers of adults* [Conference session]. Teachers and Trainers in Adult Education and Lifelong Learning: Professional Development in Asia and Europe, Bergisch Gladbach, Germany.

Хууль

Боловсролын тухай хууль 2016. (Монгол Улс). Татаж авсан холбоос <https://www.legalinfo.mn/law/details/9020>

Диссертаци

Zagir, T. (2021). *Professional identity and competences of adult learning facilitators: Perspectives from Mongolian non-formal adult education* (Doctoral dissertation). Eötvös Loránd University, Hungary. DOI: 10.15476/ELTE.2021.135

Дурдагдаагүй бусад эх сурвалжаас эш татсан бол “<https://apastyle.apa.org/style-grammar-guidelines/references>”-ээс үзнэ үү.